



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/177

Сүхбаатар сум

Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 29.2, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.4, 6.1.5, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1.9, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.3, 15.4, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймаг, сум, газар, хэлтэс, албадын албан ёсны цахим хуудсанд Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал хангалтгүй, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулаагүй, төсөлд олон нийт, сонирхогч бүлгийн санал, хүсэлтийг авах болон иргэд, аж ахуй нэгжээс санал, өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах боломжийг бүрдүүлээгүй, эрх бүхий байгууллагаас олгож буй тусгай зөвшөөрөл, түүний талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуй нэгжийн жагсаалт, үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамж, үнэ тарифын талаарх мэдээллийн хууль эрх зүйн үндэслэл, журмын хамт байршуулаагүй, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг олон нийтэд мэдээлдэггүй зэрэг зөрчил дутагдлуудыг арилгаж, мэдээллийн баяжилт болон тасралтгүй ажиллагааг хангаж ажиллахыг, нийт төр, төсвийн байгууллагуудын удирдлагууд, газар, хэлтэс, албадын дарга, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Төр, төсвийн байгууллагууд, аймаг, сумдын албан ёсны цахим хуудсанд байршуулах мэдээллийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.


3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/, тайланг нэгтгэн танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн дарга /Б.Болорзул/, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Д.Ёндонжамц/ нарт тус тус даалгасугай.

ДАРГА

Ш.ОРГИЛ



Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дүгээр
сарын 03 ний өдрийн А/177 дугаартай
захирамжийн хавсралт



АЙМГИЙН АЛБАН ЁСНЫ ЦАХИМ ХУУДСАНД МЭДЭЭЛЭЛ БАЙРШУУЛАХ ХУВААРЬ 055053

/АТГ-аас аймгийн цахим хуудсанд 2020 онд хийсэн үнэлгээнд тулгуурлав/

| № | Цахим хуудсанд оруулах мэдээллүүд | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|-----------------------------------|---|
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал /видео шторк, инфографик, нийтлэл, өгүүллэг, зурагт хуудас, авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан, мэдээ, хэвлэмэл материал г.м/ | АЗДТГ-ын бодлогын хэлтсүүд | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 2 | Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байх, төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах боломжийг бүрдүүлсэн байдал | АЗДТГ-ын ХЭЗХ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 3 | Дээрх асуудлаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцсон байдал | АЗДТГ-ын бодлогын хэлтсүүд | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 4 | Тухайн жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор/ | АЗДТГ-ын СТСХ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 5 | Өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/ | АЗДТГ-ын СТСХ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 6 | Дараа жилийн төсвийн төсөл /8 дугаар сарын 15-ны дотор/ | АЗДТГ-ын СТСХ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |

| | | | |
|----|---|--------------------------|---|
| 7 | 9.1.4.2.Жилийн эцсийн санхүүгийн тайлан /5 дугаар сарын 1-ний дотор/ | АЗДТГ-ын СТСХ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 8 | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /5 дүгээр сарын 1-ний дотор/ | АЗДТГ-ын СТСХ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 9 | Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх /өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт/ | АЗДТГ-ын СТСХ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 10 | Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/ | АЗДТГ-ын СТСХ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 11 | Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл /Бүтэн жил, сар бүр/ | АЗДТГ-ын СТСХ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 12 | Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр) | АЗДТГ-ын СТСХ, ХОХБТХ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 13 | Концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт /батлагдсанаас хойш ажлын 14 хоногт/ | АЗДТГ-ын СТСХ, ХОХБТХ | Аймаг, сумын ЗДТГ |
| 14 | Концессын гэрээ байгуулсан тухай бүр концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл /ажлын 14 өдрийн дотор/ | АЗДТГ-ын СТСХ, ХОХБТХ | Аймаг, сумын ЗДТГ |
| 15 | Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилт, явц байдлын талаарх мэдээлэл | АЗДТГ-ын СТСХ, ХОХБТХ | Аймаг, сумын ЗДТГ төр, төсвийн байгууллага |
| 16 | Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/ | АЗДТГ-ын СТСХ, ХОХБТХ | Аймаг, сумын ЗДТГ |
| 17 | Дээрх зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журам | АЗДТГ-ын СТСХ, ХОХБТХ | Аймаг, сумын ЗДТГ |
| 18 | Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл | АЗДТГ-ын | Аймаг, сумын ЗДТГ |

| | | | |
|----|---|-------------------------------|---|
| | ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацаа | СТСХ, ХОХБТХ | |
| 19 | Сул орон тооны зар /тухай бүр шинэчилсэн/ | АЗДТГ-ын ТЗУХ, ТАЗСЗ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 20 | Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам | АЗДТГ-ын ТЗУХ, ТАЗСЗ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 21 | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө | АЗДТГ-ын ХОХБТХ, ОНӨГ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 22 | Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга | АЗДТГ-ын ХОХБТХ, ОНӨГ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 23 | Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл/ | АЗДТГ-ын ХОХБТХ, ОНӨГ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 24 | Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайлан | АЗДТГ-ын ХОХБТХ, ОНӨГ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 25 | Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүн | АЗДТГ-ын ХОХБТХ, ОНӨГ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 26 | Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) | АЗДТГ-ын ХОХБТХ, ОНӨГ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 27 | Ажилтнуудын хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээлэл | АЗДТГ-ын Бодлогын хэлтсүүд | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 28 | Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээлэл | АЗДТГ-ын ХШҮДАХ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 29 | Ёс зүйн дүрэм | АЗДТГ-ын ТЗУХ, ТАЗСЗ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |

| | | | |
|----|---|----------------------------|---|
| 30 | Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдал /тушаал, захирамж/ | АЗДТГ-ын Бодлогын хэлтсүүд | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 31 | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, заавар | АЗДТГ-ын Бодлогын хэлтсүүд | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 32 | Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн үнэ, тарифын талаарх мэдээллийг хууль эрх зүйн үндэслэл журмын хамт байршуулах | АЗДТГ-ын Бодлогын хэлтсүүд | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 33 | Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр) | АЗДТГ-ын Бодлогын хэлтсүүд | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 34 | Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн эсэх | АЗДТГ-ын Бодлогын хэлтсүүд | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 35 | Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь | АЗДТГ-ын Бодлогын хэлтсүүд | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 36 | Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаарх мэдээлэл | АЗДТГ-ын Бодлогын хэлтсүүд | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 37 | Улирал жилийн үйл ажиллагааны тайлан, Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайлан | АЗДТГ-ын ХЭЗХ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 38 | Иргэд вэбсайтыг ашиглахад энгийн хялбар болгох | АЗДТГ-ын ТЗУХ | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР.